



ХЭНГИЙ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 6 сарын 28 өдөр

Дугаар А/108


Чингис хот

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай Монгол улсын хуулийн 5.1.10. дахь заалт, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын "Буцалтгүй тусламж олгох" /код 931.2.16/, цагдаагийн газрын дотоод журмын 10 дугаар зүйлийн 5 дахь заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах журам /код 136/"-ын 136.4.2-ийн "в", 136.5.2-ын "г" дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Тус аймгийн Цагдаагийн газарт цагдаагийн газрын даргаар он удаан жил үр бүтээлтэй ажилласан цагдаагийн бэлтгэл хурандаа Д.Доржид туслах аж ахуйгаас 1 /нэг/ хонь буцалтгүй тусламжийн зориулалтаар олгосугай.
2. Буцалтгүй тусламжийн 1 /нэг/ хонийг туслах аж ахуйгаас зарлагадахыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн хошууч Т.Чинбаатарт даалгасугай.
4. Тушаалыг нийт бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА



Ж.БОЛД